



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/29

Хэрлэн сум

**Ажлын байрны
тодорхойлолт батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 103.3.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай Б/46 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг мөрдүүлж ажиллахыг дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн (Ш.Эрдэнэжаргал)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

231630220